



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/12

Улаан-Уул

Захирамжийн хэрэгжилтийг
хангуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 7.12.1, 7.12.3 дахь заалт тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын шилжилт хөдөлгөөнийг хориглосон аймаг, сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангах, малын гоц халдварт шүлхий өвчин дамжин тархах эрсдэлээс урьдчилан сэргийлж, малчид, мал бүхий иргэдэд уг өвчний эдийн засгийн хор уршгийн талаарх мэдээллийг тогтмол хүргэж, анхааруулж, сэрэмжлүүлж ажиллахыг “Түйн дэлгэрэх” хоршооны малын их эмч (А.Мягмар), “ДЭНЗӨ” ХХК-ны малын их эмч (С.Даваа), “Эх тал газар” ХХК-ны малын их эмч (Г.Баасансүрэн), “Түмэн сүргийн хишиг” ХХК-ны малын их эмч /(.Ганбат) нарт, мал эмнэлгийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдийн их эмч нарыг үүрэгжүүлэн захирамжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг 7 хоног тутам авч, дүн мэдээг сумын Онцгой комисст танилцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Зоригт)-д тус тус даалгасугай.

2. Малын гоц халдварт шүлхий өвчний өнөөгийн нөхцөл байдал болон эдийн засгийн хор хохирлыг бусад аймаг, сумдаас судлан бодит баримт, тоон мэдээлэл болон өвчний талаарх гарын авлагыг бэлтгэн малчид, мал бүхий иргэдэд мэдээлэх ажлыг Мал эмнэлгийн тасаг (О.Намжирмаа), Хөдөө аж ахуйн тасгийн дарга (О.Энхболд) нарт, зэрлэг ан амьтны байршил, шилжилт хөдөлгөөний талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Т.Мөнхжаргал), багуудын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Мал амьтны шилжилт хөдөлгөөний тухай мэдээллийг үнэн зөв, цаг алдалгүй өгч, хамтран ажиллахыг малчид, мал бүхий иргэдэд уриалсугай.

642101183

4. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа хийх, болзошгүй эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах ажилд зориулж 1800000 (нэг сая найман зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын дарга (М.Зоригт), нягтлан бодогч (Ч.Батдорж) нарт зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ

